

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/202/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Нью-баланс аудит ХХК-ний партнер Б.Лхагвадорж
Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com
Аудитор: Д.Гэрэлчулуун
Утас: 99509636 Цахим хаяг: gerej_9636@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 4 |
| Асуудлыг онцолсон хэсэг | 4 |
| Аудитын гол асуудал..... | 4 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 6 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... | 12 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН..... | 16 |
| 4.1 Ерөнхий зүйл | 16 |
| 4.2 Материаллаг байдал | 16 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... | 17 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 17 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 17 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 18 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 18 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 18 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 19 |
| 5.3 Зөвлөмж | 19 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/2000
танай _____-ны № _____-т

МӨРӨН СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Г.МӨНХЦЭЦЭГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба тайлант онд улсын төсвөөс 612,231.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 12,901.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 127,962.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 203.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 9,838.4 мянган төгрөгийн алдааг залруулж, тайлант онд 1,252.1 мянган төгрөгийн төлбөр үүсгэсэнд зөвлөмж хүргүүлсэн болно.

Бусад асуудлын хэсэг

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хангалттай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 95,920,400.50 | 115,961,098.14 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 00.00 | 12,901,812.64 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 00.00 | 12,901,812.64 |
| 3121 | Төгрөг | 00.00 | 12,901,812.64 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 12,901,812.64 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 95,920,400.50 | 103,059,285.50 |
| 351 | Түүхий эд материал | 00.00 | 68,000.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 68,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 95,920,400.50 | 102,991,285.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 102,500.00 | 1,034,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 00.00 | 105,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,028,815.00 | 13,618,620.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 91,789,085.50 | 88,233,665.50 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,113,307,545.36 | 1,077,278,318.39 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,113,307,545.36 | 1,077,278,318.39 |
| 392 | Биет хөрөнгө | 967,337,645.36 | 931,455,818.39 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,046,818,028.00 | 1,046,818,028.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -165,613,032.72 | -188,599,457.52 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 76,342,333.08 | 78,571,823.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -22,768,681.16 | -31,523,694.70 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,256,248.20 | 34,874,000.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,709,294.24 | -14,566,605.31 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,834,399.00 | 10,834,399.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,822,354.80 | -4,952,674.36 |
| 393 | Биет бус хөрөнгө | 145,969,900.00 | 145,822,500.00 |
| 39301 | Програм хангамж | 147,400.00 | 147,400.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -147,400.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 145,822,500.00 | 145,822,500.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,209,227,945.86 | 1,193,239,416.53 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 1,252,119.69 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 1,252,119.69 |
| 413 | Өглөг | 00.00 | 1,252,119.69 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 1,132,019.69 |
| 4136 | Бусад өглөг | 00.00 | 120,100.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 120,100.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,209,227,945.86 | 1,191,987,296.84 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,209,227,945.86 | 1,191,987,296.84 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 265,401,125.00 | 265,401,125.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 265,401,125.00 | 265,401,125.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 860,449,755.86 | 843,209,106.84 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 860,449,755.86 | 860,449,755.86 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -17,240,649.02 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 83,377,065.00 | 83,377,065.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,209,227,945.86 | 1,193,239,416.53 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 680,453,781.08 | 775,654,280.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 595,482,481.08 | 35,460,780.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 34,278,531.08 | 35,460,780.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 34,278,531.08 | 35,460,780.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 200,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 34,278,531.08 | 35,260,780.00 |
| 122 | Тусламжийн орлого | 20,395,250.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 20,395,250.00 | 00.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 540,808,700.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 540,808,700.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 84,971,300.00 | 740,193,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 00.00 | 612,231,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 612,231,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,651,700.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,792,700.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 859,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 81,319,600.00 | 127,962,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 81,319,600.00 | 127,962,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 625,956,187.44 | 768,582,229.02 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 625,956,187.44 | 768,582,229.02 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 618,501,724.54 | 768,378,815.82 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 408,644,500.00 | 458,562,033.87 |
| 210101 | Үндсэн цалин | 298,984,405.51 | 342,131,530.89 |
| 210102 | Нэмэгдэл | 71,142,343.91 | 92,884,005.53 |
| 210104 | Урамшуулал | 38,517,750.58 | 23,546,497.45 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,128,096.82 | 57,458,232.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,654,197.50 | 38,693,467.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,187,477.13 | 4,691,141.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,262,621.84 | 3,752,872.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 699,255.46 | 938,368.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,324,544.89 | 9,382,382.28 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 70,037,874.28 | 83,924,127.97 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,686,011.52 | 6,499,352.17 |
| 210302 | Түлш, халаалт | 61,480,684.76 | 62,127,931.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,871,178.00 | 15,296,844.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,577,008.00 | 13,605,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 696,750.00 | 244,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 340,000.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 279,900.00 | 597,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 54,000.00 | 00.00 |

| | | | |
|--------|--|----------------------|-----------------------|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал | 1,788,200.00 | 1,000,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,434,930.00 | 2,329,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,983,228.00 | 9,433,900.00 |
| 2105 | Нормативт зардал | 23,660,175.00 | 90,866,745.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 995,500.00 | 519,550.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,664,675.00 | 90,347,195.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,634,900.00 | 9,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,634,900.00 | 9,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,199,800.00 | 1,009,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,479,800.00 | 15,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 994,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,619,370.44 | 53,953,526.97 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,561,359.40 | 3,432,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,565,200.00 | 4,653,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 34,492,811.04 | 45,867,626.97 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,454,462.90 | 203,413.20 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,000,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,190,825.72 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,190,825.72 | 00.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,263,637.18 | 203,413.20 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,263,637.18 | 203,413.20 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>54,497,593.64</u> | <u>7,072,050.98</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 24,807,393.86 | 24,312,700.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,814,743.86 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 21,992,650.00 | 24,312,700.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -24,807,393.86 | -24,312,700.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>29,690,199.78</u> | <u>-17,240,649.02</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | <u>625,780,000.00</u> | <u>740,393,500.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 540,808,700.00 | 200,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 200,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 200,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 200,000.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 540,808,700.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 540,808,700.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 84,971,300.00 | 740,193,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 00.00 | 612,231,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 612,231,500.00 |

| | | | |
|--------|--|-----------------------|-----------------------|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,651,700.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,792,700.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 859,000.00 | 00.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 81,319,600.00 | 127,962,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 81,319,600.00 | 127,962,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 625,780,000.00 | 727,491,687.36 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 625,780,000.00 | 727,491,687.36 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 618,325,537.10 | 727,288,274.16 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 408,644,500.00 | 457,430,014.18 |
| 210101 | Үндсэн цалин | 270,730,431.54 | 340,999,511.20 |
| 210102 | Нэмэгдэл | 99,102,265.53 | 92,884,005.53 |
| 210104 | Урамшуулал | 38,811,802.93 | 23,546,497.45 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,656,092.82 | 57,458,232.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,796,992.82 | 38,693,467.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,086,500.00 | 4,691,141.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,782,400.00 | 3,752,872.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 817,300.00 | 938,368.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,172,900.00 | 9,382,382.28 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 70,037,874.28 | 83,924,127.97 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,686,011.52 | 6,499,352.17 |
| 210302 | Түлш, халаалт | 61,480,684.76 | 62,127,931.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,871,178.00 | 15,296,844.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,226,630.00 | 00.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 760,800.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 340,000.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 279,900.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 488,200.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,992,700.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,365,030.00 | 00.00 |
| 2105 | Нормативт зардал | 29,483,890.00 | 99,937,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 995,500.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 26,590,890.00 | 99,937,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,897,500.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 37,090,900.00 | 9,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,000,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 12,000,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,090,900.00 | 9,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,204,000.00 | 1,406,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,484,000.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 00.00 |

| | | | |
|--------|--|--------------|---------------|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,406,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,981,650.00 | 18,132,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,108,600.00 | 12,042,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,873,050.00 | 6,090,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,454,462.90 | 203,413.20 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,000,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,190,825.72 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,190,825.72 | 00.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 4,263,637.18 | 203,413.20 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,263,637.18 | 203,413.20 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 12,901,812.64 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 12,901,812.64 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 12,901,812.64 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 119,578,625.00 | 16,943,555.00 | -49,764,815.34 | 86,757,364.66 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 119,578,625.00 | 16,943,555.00 | -49,764,815.34 | 86,757,364.66 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -9,058,318.76 | -9,058,318.76 |
| D01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 265,401,125.00 | 83,377,065.00 | 860,449,755.86 | 1,209,227,945.86 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 265,401,125.00 | 83,377,065.00 | 860,449,755.86 | 1,209,227,945.86 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -17,310,649.02 | -17,310,649.02 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 265,401,125.00 | 83,377,065.00 | 843,139,106.84 | 1,191,917,296.84 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|-----------------------|--|-----------------------|----------------|---------------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 | (0.00) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 740,393,600.00 | 727,288,274.16 | 13,105,325.84 | 98.23 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 740,393,600.00 | 727,288,274.16 | 13,105,325.84 | 98.23 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | | | | |

| | | | | | |
|---------|---|-----------------------|-----------------------|-----------------|---------------|
| | | 740,393,600.00 | 727,288,274.16 | 13,105,325.84 | 98.23 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 463,330,900.00 | 457,430,014.18 | 5,900,885.82 | 98.73 |
| 210101 | Үндсэн цалин | 382,168,000.00 | 340,999,511.20 | 41,168,488.80 | 89.23 |
| 210102 | Нэмэгдэл | 69,266,800.00 | 92,884,005.53 | (23,618,205.53) | 134.10 |
| 210104 | Урамшуулал | 11,897,100.00 | 23,546,497.45 | (11,649,397.45) | 197.92 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 57,857,800.00 | 57,458,232.01 | 399,567.99 | 99.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,965,300.00 | 38,693,467.46 | 271,832.54 | 99.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,723,100.00 | 4,691,141.15 | 31,958.85 | 99.32 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 3,778,500.00 | 3,752,872.90 | 25,627.10 | 99.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 944,600.00 | 938,368.22 | 6,231.78 | 99.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,446,300.00 | 9,382,382.28 | 63,917.72 | 99.32 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 84,127,400.00 | 83,924,127.97 | 203,272.03 | 99.76 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 6,703,000.00 | 6,499,352.17 | 203,647.83 | 96.96 |
| 210302 | Түлш, халаалт | 62,127,400.00 | 62,127,931.80 | (531.80) | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,297,000.00 | 15,296,844.00 | 156.00 | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 106,072,600.00 | 99,937,000.00 | 6,135,600.00 | 94.22 |
| 210502 | Хоол, хүнс | 106,072,600.00 | 99,937,000.00 | 6,135,600.00 | 94.22 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 9,000,000.00 | 9,000,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,000,000.00 | 9,000,000.00 | - | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 1,406,000.00 | 1,406,000.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 1,406,000.00 | 1,406,000.00 | - | 100.00 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,598,900.00 | 18,132,900.00 | 466,000.00 | 97.49 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,508,900.00 | 12,042,900.00 | 466,000.00 | 96.27 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,090,000.00 | 6,090,000.00 | - | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 740,393,500.00 | 740,393,500.00 | - | 100.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 612,231,500.00 | 612,231,500.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 612,231,500.00 | 612,231,500.00 | - | 100.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 127,962,000.00 | 127,962,000.00 | - | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 127,962,000.00 | 127,962,000.00 | - | 100.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 200,000.00 | 200,000.00 | - | 100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 200,000.00 | 200,000.00 | - | 100.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 12,901,812.64 | (12,901,812.64) | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 37.00 | 37.00 | - | 100.00 |

| | | | | | |
|--------|-------------------|-------|-------|---|--------|
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22.00 | 22.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14.00 | 14.00 | - | 100.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэг нь тухайн орон нутагт сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг эрхэлж байна. Тус хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд “Бага насны хүүхдийн хувийн онцлогт нийцүүлэн сургалт үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулж, гарсан ахиц амжилтыг түгээн дэлгэрүүлэх” гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг харгалзан сургалт үйл ажиллагааг хүүхдийн хувийн онцлогт нийцүүлэн төлөвлөх замаар суралцахуйн хоцрогдлыг нөхөх, тэгш боломжийг олгох
2. Суралцахуйд гарсан ахиц амжилтыг түгээн дэлгэрүүлэх туршлага солилцох, хамтран суралцах
3. Мэргэжлийн бүлгээр хамтран багшийг чадваржуулах, зөвлөх, тэргүүлэх мэргэжлийн зэргийг нэмэгдүүлэх
4. Багш ажилтныг мэргэшүүлэх, мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлэх
5. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжсэн, шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх дадал хэвшилд сургах, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
6. СӨБ-ын үйлчилгээнд 5 настай хүүхдийг бүрэн хамруулж сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах
7. Гадна дотно орчны тохижилт соёлжилтыг орчны стандартын дагуу нэмэгдүүлэх түүний осол аюулгүй, эрүүл, таатай нөхцөлийг бүрдүүлэх

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь Мөрөн сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг 85 хувь биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022

оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
- БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 01 сарын 10 өдрийн А/07 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 4 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар дараах зөрчлийг илрүүлж, 4 зөвлөмжийг удирдлагад хүргүүлж ажилласан.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу

эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,988.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---------------------|---------------------|-------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 12,901.80 | 12,901.80 |
| Бараа материал | 95,920.40 | 103,059.30 | 7,138.90 |
| Үндсэн хөрөнгө | 1,113,307.50 | 1,077,278.30 | -36,029.20 |
| Нийт хөрөнгө | 1,209,227.90 | 1,193,239.40 | -15,988.50 |
| Өр төлбөр | 0 | 1,252.10 | 1,252.10 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 265,401.10 | 265,401.10 | 0.00 |
| Хуримтлагдсан үр дүн | 860,449.70 | 843,209.10 | -17,240.60 |

| | | | |
|--|----------------------------|----------------------------|--------------------------|
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 83,377.10 | 83,377.10 | 0.00 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | <u>1,209,227.90</u> | <u>1,193,239.40</u> | <u>-15,988.50</u> |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 12,901.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 7,138,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хүүхдийн хоолны материалын үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 36,029.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,005,400.0 мянган, орон нутгийн төсвөөс, 127,962.0 мянган, төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх дүнг 559,100.0 мянган төгрөгөөр бууруулж, 574,262.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 127,962.0 мянган төгрөгөөр баталсан байна. Улсын төсвөөс авах дүнг их хэмжээгээр бууруулсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй, нөгөө талаас боловсролын салбарын төсвийн шинэчлэлтээс шалтгаалсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны А/392 тоот тушаалаар төсвийн сар, улирлын хуваарь өөрчлөлт оруулсан байна. Тус өөрчлөлтөөр анх баталсан төсвийг 165,900.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувь хагас бие даалгаж, үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны улсын төсвөөс санхүүжих дүнг 165,931.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 612,231.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 127,962.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 612,231.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 12,901.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс

127,962.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 203.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 727,300.0 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлын төсвийг 13,105.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | /мянган төгрөгөөр/ | | | |
|-----|---|--------------------|-------------------|------------------|-------------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| 1 | Эрүүл мэндийг дэмжих | 1,900.00 | 1,742.00 | 158.00 | 91.60% |
| 2 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 106,072.60 | 99,937.00 | 6,135.60 | 94.20% |
| 3 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 3,228.90 | 3,228.90 | 0.00 | 100% |
| 4 | Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 1,900.00 | 1,592.00 | 308.00 | 83.78% |
| 5 | Боловсролын стандарт, сургалтын | 418,634.10 | 416,684.70 | 1,949.40 | 99.50% |
| 6 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 80,496.00 | 76,145.00 | 4,351.00 | 94.60% |
| 7 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 93,127.40 | 92,924.10 | 203.30 | 99.80% |
| 8 | Нийтлэг үйлчилгээ | 34,834.60 | 34,834.60 | 0.00 | 100% |
| 9 | Дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан | 200.00 | 200.00 | 0.00 | 100% |
| | Нийт дүн | 740,393.60 | 727,288.30 | 13,105.30 | 98.2 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр санхүүжсэн хөтөлбөр, арга хэмжээ байхгүй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах

асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Нью-баланс аудит ХХК-ний ахлах аудитор П.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг Нью-баланс аудит ХХК-ийн захирал Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нью-баланс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 650,763.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10,412.2 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно. Тус байгууллагад дэд болон орлогч даргын орон тоо бүтэц, орон тоонд нь батлагдаагүй, албан тушаалын автомашин байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад 9,145.6 мянган төгрөгийн зардлын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нягтлан бодогчийн нэр, утасны дугаарыг сольж оруулаагүй.

3. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг журамд заасан шаардлагын дагуу байршуулаагүй, тендерт шалгарсан оролцогчийн товч мэдээлэл байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулийн холбогдох заалт, Төсвийн тухай хууль, 2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн журам заавруудын хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчилтэй асуудал илэрч байна. Үүнд:

Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаагүй ба тайланд онд 1252.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 219,500.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлсэн ба биелэлт 100 хувь байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|----------|------------------------|-----------|---------|-----------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 219,500.0 | 3 | 219,500.0 | 100 |
| Нийт дүн | 3 | 219,500.0 | 3 | 219,500.0 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлангийн толилуулгыг илэрхийлэхдээ нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй илэрхийлсэн байсныг аудитын хугацаанд залруулсан болно.

Аудитаар нийт 20,236.1 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 9,838.4 мянган төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулж, 10,397.7 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Залруулгын талаар: Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан дүн, Мөнгөн гүйлгээний тайлангийн бие болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүн 9,838.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг аудитын хугацаанд залруулсан болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад 9,145.6 мянган төгрөгийн зардлын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нягтлан бодогчийн нэр, утасны дугаарыг сольж оруулаагүй.
3. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг журамд заасан шаардлагын дагуу байршуулаагүй, тендерт шалгарсан оролцогчийн товч мэдээлэл байхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж хэвших

2. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаагүй ба тайланд онд 1252.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|----------------------------|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|---------|------------|---------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэл тайлагнал зөрүүтэй | 1 | 9,838.4 | | | 1 | 9,838.4 | 1 | 9,838.4 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|--------------------------|-------------|----------------|---------------|-----|-----------------|-----|----------|----------------|--------------------------------------|---------------------|---|----------|
| | | | | | | | | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Норм норматив хэтрүүлсэн | 1 | 1,252.1 | | | | | 1 | 1,252.1 | | | 0 | 0 |
| Дүн | 1 | 1,252.1 | | | | | 1 | 1,252.1 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|--|-------------|----------------|---------------|----------|-----------------|----------|----------|----------------|
| | | | | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээлээгүй | 1 | 9,145.6 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 9,145.6 |
| Дүн | 1 | 9,145.6 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 9,145.6 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 2/17

АХЛАХ АУДИТОР

Л.МАНДАХНАРАН ОГНОО: 11/10

БЭЛТГЭСЭН:

НЬУ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Б.ЛХАГВАДОРЖ

АУДИТОР

П.Мөнхцэцэг

П.МӨНХЦЭЦЭГ